



Эрдэм шинжилгээ, судалгааны ажил, вйлчилгээг олон улсын нийтлэг жишигт хүргэхээр ажил үүргээ гүйцэтгэж буй Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн цахим хуудаст зочилж буй Танд энэ одрийн мэнд хүргэе.

Манай хүрээлэн цэргийн шинжлэх ухааны суурь болон хавсрага судалгаа явуулж, батлан хамгаалах салбарын бодлого, вйл ажиллагаанд дүгнэлт хийх, шинжлэх ухааны

вндэслэлтэй санал, зовломж боловсруулж дэмжлэг үзүүлэх эрхэм зорилгод эрдэм ном, бүтээл туурвилын их үйлсээ зориулан 41 дэх жилтэйгээ золголоо.

Монгол Улсын тороос шинжлэх ухааны салбарын эрх зүйн орчныг сайжруулах, вндэсний шинжлэх ухаан, технологи, инновацийг хөгжүүлэх, судалгаа хөгжүүлэлтийн ажлын чанар, үр огоож, внэлэмжийг дээшлүүлэхэд анхаарч, хөгжлийн бодлогоо шинжлэх ухаанд суурилан тодорхойлох чиглэлийг баримталж байна.

Тороос шинжлэх ухааны талаар баримтлаж буй бодлогын хүрээнд батлан хамгаалах салбар, тэр дундаа аюулгүй байдал, батлан хамгаалах судлал, вндэсний цэргийн урлаг, технологи дамжуулалт, реинженеринг, цэргийн түүхийн чиглэлээр судалгаа хөгжүүлэлтийн ажлыг шинэ шатанд гаргахаар зорьж байгаагаа шинжлэх ухаанаар овоглосон хүрээлэнгийнхээ эрдэмтэн судлаачдыг толоолон Та бүхэнд дуулгахдаа таатай байна.

Та бүхэн манай цахим хуудсаар зочилж, мэдээлэл авч бидэнтэй хамтран ажиллана гэдэгт итгэж байна.

Эрдэмтэн судлаачдын туурвисан, бүтээсэн болгон Эх орны маань хөгжилд ашиглагдаж, туурга тусгаар Монгол Улсын тусгаар тогтнол бат сайхан орших болтугай.

ЗАХИРАЛ, ДОКТОР (Ph,D), ПРОФЕССОР

ХУРАНДАА Б.ЭРДЭНЭБАТ